

“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/95 дугаар тушаалын хавсралт



ЭКСКАВАТОРЫН ОПЕРАТОРЫН АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

Компани:	“Эрдэнэс алт ресурс” ХХК	Нэгж	Үйлдвэрлэл, технологийн газрын Салхит уулын баяжуулах үйлдвэрийн Засвар механикийн хэсэг
Шууд харьяалагдах албан тушаалын нэр:	- Салхит уулын баяжуулах үйлдвэрийн захирал - Ахлах инженер - Механик инженер		
Шууд бус харьяалагдах албан тушаалын нэр:	- Гүйцэтгэх захирал - Үйлдвэрлэл, технологийн газрын захирал		
Шууд харьяалах албан тушаалын нэр:			
Шууд бус харьяалах албан тушаалын нэр:	-		
Ажлын байрыг түр орлох албан тушаал:	- Экскаваторын оператор - Ковшийн оператор		

ХОЁР. АЖЛЫН ЗОРИЛГО, ЧИГ ҮҮРЭГ

2.1 Ажлын зорилго:

Урвуу утгуурт экскаваторыг аюулгүй, тогтвортой ажиллуулах, тэдгээрийг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засвар үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэхэд хяналт тавих, хамтран ковшыг аюулгүй, тогтвортой ажиллуулах, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засвар үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэх

2.2 Ажлын чиг үүрэг:

Үндсэн чиг үүргүүд:		
1	Нэн тэргүүнд аюулгүй ажиллагааг эрхэмлэн урвуу утгуурт экскаваторыг молдок нэмэлт тоноглолын хамт /ковш, автогрейдер, болон сэрээт ачигч/ийн техникийн бэлэн байдал, найдвартай ажиллагаа, ажиллах орчны аюулгүй байдлыг хангасны дараа ажлыг гүйцэтгэх	Т
2	Машин механизм тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд Механикт цаг алдалгүй мэдээлэх	Т

3	Ээлж хүлээлцэх бүрд техникийн бүрэн бүтэн байдал, хэвийн үйл ажиллагааг шалгаж хүлээн авах	
4	Хариуцсан техникийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засвар, үйлчилгээг засварчинтай хамтран хийж гүйцэтгэх	Т
5	Хариуцсан техникийн их болон урсгал засвар, техник үйлчилгээг гүйцэтгэхэд гагнуурчин/засварчин болон бусад ажилтнуудад зааврын дагуу тусалж, чанарт хяналт тавьж техникээ хүлээн авах	Т
6	Хариуцсан техник хэрэгслийн үзлэг, тосолгоо, цэвэрлэгээг ажил эхлэхийн өмнө хийж гүйцэтгэх	Т
7	Хариуцсан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хариуцах	Т
8	Техник төлөвлөлтийн хэсгийн ажлаас гадна уурхайн бусад тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх. Шаардлагатай тохиолдолд дамп, хүнд даацын тээврийн хэрэгсэл, автокран ажиллуулах	Т
9	Уурхайн бүсэд өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд яаралтай хийгдэх шаардлагатай ажилд биечлэн оролцох, механизмаар туслах	Т
Бусад чиг үүргүүд:		
10	Төлөвлөгөөт сул зогсолтын хугацаанд үндсэн чиг үүргээс гадна өгөгдсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэх	
11	Хариуцсан ажлын хүрээнд гаднын байгууллагуудтай хамтран ажиллахтай холбоотой баримт бичиг боловсруулах	Т
12	Уулын болон үйлдвэрлэлийн холбогдох нууцын журмаар зохицуулсан нууцтай холбоотой мэдээ мэдээллийг чандлан хадгалж ажиллах	Ө
13	Хариуцсан ажлын хүрээнд тайлан статистик үзүүлэлтийг сар, улирал, жилээр гарган тайлагнах	Т
14	Удирдлагын зүгээс өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх	Т
15	Хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд эрсдэлийн төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлэн ажиллах	Ж
16	ХАБЭА-н тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан нийтлэг үүргийг хүлээнэ. Үүнд: - хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөх; - хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх, хуульд тусгайлан заасан бол шалгалт өгсөн, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх; - хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй байдлын дүрэм, журамд заасны дагуу шуурхай арга хэмжээ авах; - эрүүл мэндээ хамгаалах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орох; - ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх; - ажил, үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, осол гэмтэл, хурц хордлогоос сэргийлэх, болзошгүй аюул, ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх; - өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх;	Ө

	- ажил олгогчийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах.	
17	Компанийн дотоод ажилд идэвхитэй оролцох	Т
18	Ажил үүргийн үндсэн чиглэлээс гадна Гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах	Т

Дагтамжийн үсгэн тэмдэглэгээний тайлбар:

Ө - өдөр бүр, Т – Тухай бүр, Д - 7 хоног бүр, С - сар бүр, У - улирал бүр, Х - хагас жил бүр, Ж - жил бүр

2.3 Ажил үүргийг хэмжих үзүүлэлт

- Төлөвлөгөөт ажил үүргийн гүйцэтгэл, биелэлт
- Ажлын тайлан
- Үүрэг даалгаврын биелэлт

ГУРАВ . ТАВИГДАХ ШААРДЛАГА

Боловсрол:	Бүрэн дунд болон түүнээс дээш зэрэг	
Мэргэжил:	Экскаваторын сертификат, Монгол улсын С,М ангиллын хүчин төгөлдөр жолооны үнэмлэхтэй байх	
Мэргэшил:		
Туршлага:	Экскаватор дээр 3-аас доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар:	Дүн шинжилгээ хийх	- Ажил мэргэжлээс шалтгаалах аюул эрсдэл болон аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга замыг мэдэх, аюулгүй ажиллагааны туршлагуудыг эзэмшсэн, аюулыг таньдаг байх - Техник сэтгэлгээтэй, гарын мэдрэмжтэй, нягт нямбай, хүчлийн орчинд ажиллах, ажил мэргэжлийн ёс зүйтэй байх - Эвдрэл гэмтлийг оношлох чадвартай байх
	Багаар ажиллах	- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцах, хамтран ажиллах, үлгэрлэн манлайлах, - Хувийн зохион байгуулалт сайтай - Бүтээлч санаачлагатай ажилах
	Мэргэжлийн	- Урвуу утгуурт экскаваторыг зааврын дагуу ажиллуулах чадвартай, туршлагатай байх. Технологийн паспортын дагуу ачих, ухах ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэдэг байх - Ажлыг төлөвлөх, хариуцан хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах чадвартай - Экскаваторын нэмэлт тоноглол молдок салгаж угсрах, ашиглах АА-ны зааврыг бүрэн ойлгож мэдсэн байх, туршлагатай байх


		- Урвуу утгуурт экскаваторын төлөвлөгөөт үйлчилгээ болон жижиг эвдрэл гэмтлийг оношилж, засварлах чадвартай байх - Хариуцсан техникийн өдөр тутмын үзлэг, тосолгоог тогтмол хийдэг байх. Үзлэгийн хуудсыг үнэн зөв бөглөж механик инженерт өгдөг байх
	Бусад	- Ажил, үүргээ гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн байх; - Өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх; - Харилцааны ур чадвартай байх, - Түргэн шуурхай ажиллах чадвартай,
Тусгай шаардлага:		
1. Машин механизмын урсгал засварын ажлыг бие даан хийдэг байх		
Компьютер:	-	
Оюуны:	-	Ажлын ачаалал даах чадвартай байх
Биеийн :	-	Эрүүл мэндийн шаардлагад нийцсэн
Гадаад хэл	-	

ДӨРӨВ. ХУЧИН ЗҮЙЛС

1. Ажлын байрны харилцах субъект		
1.1. Байгууллагын дотор талд байгаа	1.2. Байгууллагын гадна талд байгаа	
• Бүх газар, хэлтэс, албаны ажилтнууд.	<i>Шууд харилцах байгууллага:</i> - Туслан гүйцэтгэгч компаниуд <i>Шууд бус харилцах байгууллага:</i> -	
2. Ажлын байрны нөөц, хэрэгсэл	2.1. Санхүүгийн нөөц	- Гүйцэтгэх захирлын баталсан цалингийн сүлжээгээр тогтоогдоно. - Урамшуулал нь гүйцэтгэлийн үнэлгээний журмын хүрээнд тогтоогдоно. - Компанийн хөдөлмөрийн дотоод журам, цалин хөлсний журамд заасан бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлс
	2.2. Биет хөрөнгийн нөөц	- Эд хөрөнгийн бүртгэлийн картад бүртгэгдсэн тавилга - Машин механизм, техник хэрэгсэл, ажлын үнэмлэх,
	2.3. Бусад	-
	3.1. Ердийн нөхцөл	- Ажлын хэвийн / хэвийн бус орчин, нөхцөл

3. Ажлын байрны нөхцөл	3.2. Онцгой нөхцөл	-
4. Шийдвэр гаргах эрх хэмжээ	4.1. Өөрийн хариуцсан ажил үүрэгтэй холбоотой асуудлыг өгөгдсөн эрхийн хүрээнд шийдвэрлэх, шаардлагатай бол Гүйцэтгэх захиралд танилцуулан шийдвэрлүүлэх 4.2. Компанийн үйл ажиллагаатай холбоотой өөрт хамаарах бүх төрлийн мэдээлэл, баримттай танилцах 4.3. Компанийг өөрийн хариуцсан ажлын хүрээнд төлөөлөх, шаардлагатай бусад асуудлаар өгөгдсөн эрхийн хүрээнд төлөөлөх, уулзалт, семинар, хуралд оролцох 4.4. Байгууллагуудтай компанийн нэрийн өмнөөс харилцан, мэдээлэл солилцох, хамтран ажиллах	
5. Хариуцлага хүлээх	5.1. Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, хариуцсан нэгжүүдийн ажлын чиг үүргийг хэрэгжүүлээгүй, ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргээ биелүүлээгүй, хангалтгүй биелүүлсэн, хөдөлмөрийн гэрээ болон компанийн Хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн бол Компанийн Хөдөлмөрийн дотоод журам, дүрэм, Хөдөлмөрийн тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжуудад заасны дагуу хариуцлага хүлээнэ	

ТАВ. БАТАЛГААЖУУЛАЛТ

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан:	Ажлын байрны тодорхойлолтыг хянасан:
Захиргааны хэлтсийн дарга  Б.Өнөржаргал	Захиргаа, удирдлагын газрын захирал  О.Дагвадорж
2026 оны 03 сарын 17-ны өдөр	2026 оны 03 сарын 17-ны өдөр
Ажлын байрны тодорхойлолттой танилцсан ажилтан:	
Экскаваторын оператор / 2026 оны сарын-ны өдөр	